



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ

Агуулга

Нэг. Нийтлэг үндэслэл	2
Хоёр. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилоход оролцогч талуудын эрх, үүрэг...	3
Гурав. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур	4
Дөрөв. Сонгон шалгаруулалт зохион байгуулах	4
Тав. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх	6
Зургаа. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийг үнэлэх, сонгон шалгаруулах	6
Долоо. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон томилох	7
Найм. Хяналт, хариуцлага	7
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын	8
Хавсралт 1	8
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын	10
Хавсралт 2	10
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын Хавсралт 3	12
Маягт 1	12
Маягт 2	13
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын Хавсралт 4	15

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам (цаашид “Журам” гэж)-ын зорилго нь Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүдэд тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох, гишүүнийг шалгаруулах, нэр дэвшүүлэх, сонгох, томилох үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг явуулах болон нэр дэвшүүлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагууд болон Банкны дүрэм, журмыг мөрдөн, хэрэгжилтийг хангана.
- 1.3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг үнэлэх, сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэхэд ил тод нээлттэй байдлыг хангах, мэргэшсэн, олон талт, үр дүнтэй бүтцийг бүрдүүлэх, банкны үйл ажиллагаа, стратегийн зорилттой уялдуулах, ТУЗ-ийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, шударга, ёс зүйтэй байх зарчмыг баримтална.
- 1.4. ТУЗ-ийг олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байхаар бүрдүүлнэ.
- 1.5. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, шинээр нэр дэвшүүлэх гишүүний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо Банкны үйл ажиллагааны онцлог, урт хугацааны стратегийн зорилго, зорилттой уялдуулна.
- 1.6. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг явуулахдаа банкны эрх ашгийг хүндэтгэн, шударга ёс зүйтэй хандана.
- 1.7. Энэхүү журам нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд Банкны ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч, Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх), ТУЗ-ийн гишүүд, Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (цаашид “ЦУНДХ” гэх), ТУЗ-ийн дэргэдэх Ажлын алба (цаашид “ТУЗДАА” гэх)-нд хамаарна.
- 1.8. Энэхүү Журмын хүрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.8.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч: Банкны саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч иргэн;
 - 1.8.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч: Банкны ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад орж, ЦУНДХ-ны зүгээс тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлт хийсний үндсэн дээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр сонгогдсон хувь хүн;
 - 1.8.3. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогч: Банкны зүгээс зарласан ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруултанд оролцож, нэр дэвших хүсэлтээ өгсөн хувь хүн;
 - 1.8.4. Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо: ТУЗ-ийн дэргэдэх хороо бөгөөд Банкны ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох, тус шалгуурыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх эрх бүхий хороо;
 - 1.8.5. Эрх бүхий албан тушаалтан: Банкны ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Дотоод аудитын газрын захирал, Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал зэрэг Банкны дүрмийн 12.1-д заасан банкны албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээд.

Хоёр. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилоход оролцогч талуудын эрх, үүрэг

2.1. ХЭХ-ын эрх, үүрэг:

2.1.1. Хувьцаа эзэмшигч нар ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хууль, дүрэм журмын дагуу явагдсан эсэхэд хяналт тавих эрхтэй бөгөөд ХЭХ-аар ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгон томилно.

2.2. ТУЗ-ийн эрх, үүрэг:

2.2.1. ТУЗ нь удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг ХЭХ-аар сонгох хүртэл түр томилж болно.

2.3. ЦУНДХ-ны эрх, үүрэг:

2.3.1. ЦУНДХ нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдэн, сонгон шалгаруулалтыг дотоод эсхүл гадаад эх үүсвэрээс зарлах шийдвэрийг гаргана.

2.3.2. Хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нийтэд нээлттэй байдлаар зарлан явуулахыг зорих ба Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” -ыг мөрдлөг болгон сонгон шалгаруулалтыг хийнэ.

2.3.3. ЦУНДХ нь ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо, ажлын тайлан, гүйцэтгэлтэй танилцан, Банкны урт хугацааны стратеги төлөвлөлт, бизнесийн чиг хандлагатай уялдуулан ТУЗ-ийн гишүүдийг улираан нэр дэвшүүлэх, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг хэлэлцэн гаргана.

2.3.4. ЦУНДХ-ны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд ердийн болон хараат бус гишүүдийн тоо, шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүдийн хэрэгцээ, мэргэжил, ур чадварын нэмэлт шалгуурыг тодорхойлно.

2.3.5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлтийг тогтоон, тус шалгуурын дагуу ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийг үнэлэн, дүгнэлт өгч, ХЭХ-д санал болгон нэр дэвшүүлнэ.

2.4. ТУЗДАА-ны эрх, үүрэг:

2.4.1. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, холбогдох хууль тогтоомж болон Банкны дүрэм, Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын хүрээнд ТУЗДАА нь энэхүү Журамд хоёр жил тутамд нэг удаа эргэн хяналт хийх ба шаардлагатай тохиолдолд энэхүү Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, ЦУНДХ-нд танилцуулан хянуулж, ТУЗ-ийн хурлаар батлуулна.

2.4.2. ТУЗДАА нь ЦУНДХ-ны сонгон шалгаруулалтыг дотоод эсхүл гадаад эх үүсвэрээс зарлах шийдвэрийг үндэслэн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зарлах, сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх, материалыг нь бүрдүүлэх, ЦУНДХ-ны хурлаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангана.

2.4.3. ТУЗДАА нь сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичиг энэхүү журам болон бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн танилцуулгыг ЦУНДХ-нд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

2.4.4. ТУЗДАА нь ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тухай бүр банкны “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын дагуу мэдээллийг олон нийтэд хүргэж, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангана.

2.5. Эрх, үүргийн матриц:

Хүснэгт 1. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх эрх, үүргийн матриц

№	Процесс	ХЭХ	ТУЗ	ЦУНДХ	ТУЗДАА
<i>/Г-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах /</i>					
1	Нэр дэвшигчид тавих шалгуурыг тогтоох	М	З, Г	Х, Г	Г
2	ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдэх, сонгон шалгаруулалт зарлах, шийдвэрийг гаргах	М	З, Г	Х, Г	З
3	Сонгон шалгаруулалт зарлах, бүртгэх	М	З, М	Г	Х, Г
4	Анкетны сонгон шалгаруулалт	М	М	Х, Г	З
5	ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, дүгнэлт өгөх	М	З, М	Х, Г	З
6	Нэр дэвшигчдийг ХЭХ-д нэр дэвшүүлж, томилуулах шийдвэр гаргах	М	З, М	Х, Г	З
7	ТУЗ-ийн гишүүнийг түр томилох	М	Х, Г	З	З
8	ТУЗ-ийн гишүүдийг томилох	Х, Г	З	З	З
9	ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих	Х	-	-	З
10	ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх	М	М	М	Х, Г

Гурав. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур

- 3.1. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах хуулийн шалгуур:
 - 3.1.1. Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг заасан шалгуурыг хангасан байх;
 - 3.1.2. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.
- 3.2. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах хуулийн шалгуур:
 - 3.2.1. Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан байх;
 - 3.2.2. Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын шалгуурыг хангасан байх;
 - 3.2.3. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.
- 3.3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шалгуур үзүүлэлт:
 - 3.3.1. Банктай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч байгууллагад ажил үүрэг хашдаггүй байх;
 - 3.3.2. Хангалттай цаг зарцуулж ажиллах боломжтой байх;
 - 3.3.3. Ёс суртахууны өндөр төлөвшилтэй байх;
 - 3.3.4. Идэвх санаачилгатай, хариуцлагатай байх;
 - 3.3.5. Аливаа асуудалд дүн шинжилгээ хийж, асуудлыг оновчтой шийдвэрлэх чадвартай;
 - 3.3.6. ЦУНДХ-ноос шинээр бүрдүүлэх ТУЗ-ийн гишүүний хэрэгцээ шаардлагатай уялдуулан тодорхойлсон бусад нэмэлт шалгуур.
- 3.4. Гүйцэтгэх удирдлагын багт ажилладаг ТУЗ-ийн гишүүнд тавигдах хуулийн хязгаарлалт:
 - 3.4.1. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, ЦУНДХ-ны гишүүн байж болохгүй.
 - 3.4.2. Гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, хяналт тавих, үнэлэхтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргахад саналын эрхгүй байна.

Дөрөв. Сонгон шалгаруулалт зохион байгуулах

- 4.1. ЦУНДХ нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдэн, сонгон шалгаруулалтыг дотоод эсхүл гадаад эх үүсвэрээс зарлах шийдвэрийг гаргана.

- 4.2. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчоос дараах баримт бичгийг хүлээн авна. Үүнд:
- 4.2.1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;
 - 4.2.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн анкет, цээж зураг (Хавсралт 1);
 - 4.2.3. Ажил байдлын тодорхойлолт (ажил эрхэлдэг иргэн байгууллагаасаа тодорхойлолт авах, ажил эрхэлдэггүй иргэн өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар мэдээлэл);
 - 4.2.4. Мэргэжлээрээ болон банк, санхүүгийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан ажлын туршлагатайг нотлох баримт, тодорхойлолт;
 - 4.2.5. Иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 4.2.6. Боловсролын диплом, үнэмлэх, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
 - 4.2.7. Компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
 - 4.2.8. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт;
 - 4.2.9. Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
 - 4.2.10. Эрүүгийн хариуцлага, ял шийтгэл хүлээж байсан эсэх, хүлээж байгаа эсэх тодорхойлолт, лавлагаа;
 - 4.2.11. Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар хувийн эсхүл мэргэжлийн ёс зүйгүй байдлыг тогтоож үйл ажиллагааг нь зогсоож байсан эсэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны лавлагаа буюу тодорхойлолт;
 - 4.2.12. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн өөрийгөө үнэлэх хуудас (Хавсралт 2);
 - 4.2.13. Холбогдох хууль тогтоомжид заасан Банкны ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан болохыг нотлоход шаардлагатай бусад баримт.
- 4.3. ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчоос энэхүү Журмын 4.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг хүлээн авна. Үүнд:
- 4.3.1. Банк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүйг нотлох баримт;
 - 4.3.2. Энэхүү Журмын 1.8.1-т заасан этгээдийн холбогдох этгээд биш болохыг нотлох баримт;
 - 4.3.3. Банкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх болохыг нотлох баримт;
 - 4.3.4. Банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй болохыг нотлох баримт;
 - 4.3.5. төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй болохыг нотлох баримт;
 - 4.3.6. эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүйг нотлох баримт;
 - 4.3.7. Холбогдох хууль тогтоомжид заасан Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан болохыг нотлоход шаардлагатай бусад баримт.
- 4.4. Шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар зарлан явуулахыг зорих бөгөөд шаардлагатай тохиолдолд өмнө нь сонгон шалгаруулалтад оролцсон ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчид дундаас шууд сонгох байдлаар зохион байгуулж болно.
- 4.5. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлах байдлаар буюу гадаад эх үүсвэрээс бүрдүүлж зохион байгуулах тохиолдолд ТУЗДАА дараах хэлбэрүүдээс сонгож олон нийтэд сонгон шалгаруулалтын зарыг түгээнэ. Үүнд:
- 4.5.1. Банкны албан ёсны цахим хуудас; эсхүл
 - 4.5.2. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл.

- 4.6. Сонгон шалгаруулалтын зард дараах мэдээллийг тодорхой тусгана. Үүнд:
 - 4.6.1. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлт;
 - 4.6.2. Материал хүлээн авах хаяг, хугацаа, холбоо барих мэдээлэл;
 - 4.6.3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн анкетын загвар (Хавсралт 1).
- 4.7. ТУЗДАА нь ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогч, нэр дэвшигчээс өгсөн итгэмжлэл, зөвшөөрлийн дагуу сонгон шалгаруулалттай холбоотой нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээллийг эрх бүхий байгууллагаас гаргуулан авч болно.
- 4.8. ТУЗДАА нь ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчоос ирсэн бичиг баримт, материалыг бүртгэн хүлээн авч, анкетийн сонгон шалгаруулалтыг хийж, сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг ЦУНДХ-нд хүргүүлнэ.
- 4.9. Өмнө нь сонгон шалгаруулалтад материалаа ирүүлж байсан ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчид дундаас сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тохиолдолд ТУЗДАА нь боломжит нэр дэвшигчдийн анкет, материалыг ЦУНДХ-ны гишүүдэд хүргүүлнэ.

Тав. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх

- 5.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор ЦУНДХ, эсхүл Гүйцэтгэх захиралд гаргаж болно.
- 5.2. Гүйцэтгэх захирал нь энэхүү Журмын 5.1-д заасны дагуу ирүүлсэн саналыг ЦУНДХ-нд ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.
- 5.3. Энэхүү Журмын 5.1-д заасан хувьцаа эзэмшигч нэр дэвшүүлэх хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийнх нь нэр, хэрэв банкны хувьцаа эзэмшигч бол түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоог тусгасан мэдэгдлийг бичгээр гаргах бөгөөд нэр дэвшүүлж байгаа үндэслэлээ зааж болно. Мөн уг мэдэгдэлд санал гаргаж буй нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эзэмшлийн хувьцааны төрөл, тоог тусгана.
- 5.4. ЦУНДХ нь энэхүү Журмын 5.1-т заасны дагуу гаргасан саналыг дор дурдсанаас бусад тохиолдолд хүлээн авч, нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэн ТУЗ-д танилцуулж, ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад уг саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор багтаан оруулах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 5.4.1. Санал гаргагч нь энэхүү Журмын 5.1-д заасан шаардлагыг хангаагүй;
 - 5.4.2. Энэ журмын 5.3-т заасан мэдээллийг бүрэн тусгаагүй;
 - 5.4.3. Хууль тогтоомжид заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах шалгуурыг хангаагүй.
- 5.5. ЦУНДХ нь Журмын 5.1-т заасны дагуу гаргасан саналыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах саналыг ТУЗ-д гаргах, эсхүл нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид бичгээр хүргүүлнэ.
- 5.6. Журмын 5.5-д заасан ЦУНДХ-ны шийдвэрийн талаар санал гаргагч шүүхэд гомдол гаргаж болно.

Зургаа. ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийг үнэлэх, сонгон шалгаруулах

- 6.1. Журмын 4.1-т заасны дагуу дотоод болон гадаад эх үүсвэрээс ирсэн ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн бичиг баримт, материалууд, ТУЗДАА-ны хийсэн анкетын сонгон шалгаруулалт дээр үндэслэн ЦУНДХ-ны гишүүд нь ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчдыг Журмын Хавсралт 3-ын Маягт 1 эсвэл Маягт 2-ын үнэлгээний асуултын дагуу үнэлнэ.
- 6.2. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчтой цахим эсвэл биечилсэн ярилцлага нэмэлтээр хийж болно.
- 6.3. ЦУНДХ-ны гишүүд нь ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчдод үнэлгээ хийн, хэлэлцэн, дүгнэлт гаргасны үндсэн дээр ХЭХ-д нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийг эцсийн байдлаар сонгон шалгаруулж, нэр дэвшигчдийн жагсаалтыг Хавсралт 4-ийн дагуу батлан гаргана.
- 6.4. ТУЗДАА нь сонгон шалгаруулсан нэр дэвших этгээдийн Банкны дүрэм, Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт тус тус заасан шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичгийг сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 5 (таван) өдрийн дотор Монголбанканд хүргүүлнэ.
- 6.5. Энэхүү Журмын 5.5-т заасан шийдвэр, 6.3-т заасан дүгнэлт эсхүл Монголбанкны мэдэгдлийн дагуу ХЭХ-д нэр дэвшүүлэгдээгүй ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримтыг ТУЗДАА архивлан хадгална.

**Долоо. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх,
сонгон томилго**

- 7.1. ЦУНДХ нь энэхүү Журмын 6.3-т заасны дагуу холбогдох шаардлагыг хангасан гэж үзсэн бөгөөд гишүүнд нэр дэвших этгээдийн холбогдох шалгуур, шаардлага хангаж буй талаар Монголбанкны мэдэгдлийг хүлээж авсан нэр дэвшигчдийн жагсаалтыг ТУЗ-д танилцуулж, ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулна.
- 7.2. ТУЗ-ийн гишүүнийг ХЭХ-аар санал хураах кумулятив аргаар сонгон томилно.
- 7.3. ХЭХ-аас ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон нэр дэвшигчээс энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлсэн баримтыг тухайн гишүүний хувийн хэрэгт хадгална.
- 7.4. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг ХЭХ-аар сонгох хүртэл ТУЗ-өөс түр томилж болно.
- 7.5. Журмын 7.4-д заасны дагуу томилогдсон гишүүн нь Журмын 3 дугаар зүйлд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

Найм. Хяналт, хариуцлага

- 8.1. Хувьцаа эзэмшигч нар нь ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хууль, дүрэм, журмын дагуу явагдсан эсэхэд хяналт тавих эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн зүгээс хүсэлт гаргасан тохиолдолд ЦУНДХ нь ТУЗДАА-аар дамжуулан сонгон шалгаруулалтын явц, үр дүнг ил тодоор мэдээлэх үүрэгтэй.
- 8.2. ЦУНДХ, ТУЗ болон ТУЗДАА нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах болон нэр дэвшүүлэх үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан үүргийг мөрдөж ажиллаагүй, зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.


Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг
сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын
Хавсралт 1



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ**

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Эцгийн нэр, нэр:	
Төрсөн он, сар, өдөр	
Регистрийн дугаар:	
Иргэншил:	
Оршин суугаа хаяг:	
Суурин болон гар утасны дугаар:	
Цахим шуудангийн хаяг:	



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Боловсрол	Эзэмшсэн боловсрол/ хамгаалсан цол	Суралцсан хугацаа	Сургуулийн нэр	Улс, хотын нэр

3. Ажил эрхлэлт

3. Ажил эрхлэлт				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Албан тушаалд томилогдсон огноо				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Өмнөх хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон ба чөлөөлөгдсөн огноо	Ажлаас гарсан, шалтгаан
...				
...				
...				

4. Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бол доорх хүснэгтийг бөглөнө үү.

д/д	Оноосон нэр, Бүртгэлтэй улсын нэр	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар	Холбоо барих хаяг
1				
2				
...				

5. Хуулийн этгээд /4-д дурьдсан/, банкны хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол доорх хүснэгтийг бөглөнө үү.

№	Оноосон нэр, бүртгэлтэй улсын нэр	Эзэмшлийн хувь	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар

6. Гадаад хэлний чадвар /√ тэмдэглэгээ хийнэ үү//

Гадаад хэл	Ярих			Унших			Бичих			Сонсох		
	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу

7. Гишүүнчлэл

№	Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох	Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Тайлбар

Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.

8. Одоогийн хашиж байгаа ажил, албан тушаал төрийн албанд хамаардаг эсэх
 Үгүй Тийм

Хэрэв тийм бол албан байгууллага болон албан тушаалын нэр:

.....

Төрийн албан тушаалын төрөл:

Төрийн улс төрийн албан тушаал	
Төрийн захиргааны албан тушаал	
Төрийн тусгай албан тушаал	
Төрийн үйлчилгээний албан тушаал	

9. Гэр бүлийн байдал (гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээллийг оруулна уу)

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал	Улс төрийн нөлөө бүхий этгээд эсэх

Гарын үсэг /баталгаат/

/...../

/Овог, нэр/

/гарын үсэг/

Огноо: он сар өдөр



**ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн өөрийгөө
үнэлэх хуудас**

Доор дурьдсан тэмдэглэгээнээс тохирохыг тэмдэглэгээ багананд бөглөнө үү.

- Тус чиглэлээр ажиллаж байсан туршлагатай - А
- Тус чиглэлээр одоо ажиллаж байгаа - В
- Ойлголтын түвшний мэдлэгтэй - С
- Ойлголт байхгүй - D

Ур чадвар/ салбар	Тэмдэглэгээ	Тайлбар
Аудит ба комплайнс Гүйцэтгэл ба зохицуулалтын стандарт, шалгалт, аудитын журам		
ТУЗ-ийн гишүүд ба удирдлагын гүйцэтгэл ТУЗ, гишүүд, Гүйцэтгэх захирал, удирдах албан тушаалтанаар ажилласан байдал		
Үйл ажиллагаа Бизнесийн загвар, үйл ажиллагааны гол бүрдүүлэгч (хүмүүс, биет ба техникийн дэд бүтэц), үйл ажиллагааны эрсдэл, бизнесийн тасралтгүй байдал		
Санхүүгийн мэдлэг/туршлага Санхүүгийн тайлан, гүйцэтгэлийн үзүүлэлтийг ойлгох, уншиж чаддаг байх		
Засаглал ба ёс зүй ТУЗ-ийн үүрэг хариуцлага, бүтэц, шийдвэр гаргах эрх мэдэл, ТУЗ-ийн бодлого, үйл явц, Хороод (бүрэн эрх, бүтэц, үйл явц), Компанийн сайн засаглалын хувьсал		
Удирдах чадвар Удирдлагын зан чанар, чадвар, үр дүнтэй мэргэжлийн болон хувийн зан чанар		
Зохицуулалтын орчин Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хяналт, санхүүгийн үйлчилгээний хууль тогтоомж болон Засаглалын удирдамж, зохицуулагч албан тушаалтан/байгууллага		
Эрсдэл ба хөрөнгийн удирдлага, стратеги/засаглал, чанаргүй активын удирдлага Санхүү, үйл ажиллагааны эрсдэлийн хяналт шалгалт, эрсдэлийн аппетит, соёл, хөрөнгийн хуваарилалт, төлөвлөлт, эрсдэлээр жигнэсэн гүйцэтгэлийн хэмжүүр, стресс-тест, бүтцийн өөрчлөлтийн шийдэл, авлага цуглуулах стратеги, чанаргүй зээлийг худалдах		
Стратеги Стратеги төлөвлөлтийн ойлголт, процесс, стратегийн тодорхой чиглэлийн ач холбогдол, бизнес/бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний хяналт, төсвийн гүйцэтгэл		

<p>Мэдээллийн технологи, түүний стратеги, “Big data” -ийн удирдлага, дижитал шилжилт, Финтек</p> <p>Сүлжээ, банкны бизнесийн систем, мэдээллийн сангийн удирдлага, цахим хуудсаар дэмжигдсэн үйлчилгээ, техник хангамж, программ хангамж</p>		
<p>Нэгтгэх, худалдаж авах, /Хөрөнгийн зах зээл/Хөрөнгө оруулалтын банк</p> <p>Нэгтгэх, худалдаж авах стратеги, хөрөнгө оруулалт/салгах стратеги, тогтмол орлого ба хөрөнгө оруулалтын зах зээл, патент, эрхийн арилжаа</p>		
<p>Гүйцэтгэх засаглал ба хүний нөөцийн удирдлага</p> <p>Ажилд авах, боловсон хүчний сонголт, шалгуур, практик, гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллыг эрсдэлийн аппетиттай зэрэгцүүлэх, хугацаанаас өмнө тэтгэвэрт гарах схем</p>		
<p>Зээлийн үйл ажиллагаа</p> <p>Иргэд, жижиг, дунд бизнес, байгууллага, банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, чанаргүй зээлийн удирдлага</p>		
<p>Хууль, эрх зүй</p> <p>Компанийн болон Банкны хууль эрх зүйн хүрээ, анхаарал хандуулах актив, хөрөнгийн зах зээлтэй холбоотой хууль эрх зүйн хүрээ</p>		
<p>Бусад ур чадвар, мэдлэг чадварын хүрээ (өөрийн мэргэжлээр болон бусад чиглэлээр ажилласан байдал, туршлага)</p>		

* энэхүү асуулга нь сонгон шалгаруулалтын явцад ЦУНДХ-ны гишүүдэд ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчийн талаар нэмэлт мэдээлэл олгоход зориулагдана.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон
шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын Хавсралт 3
Маягт 1



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ҮНЭЛГЭЭ

НЭГ. Нэр дэвшигчийн эцгийн нэр, нэр: _____

I.Компанийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх

№	Шалгуур	Үнэлгээ (Тийм/Үгүй)	Баталгаажуулах материал
1	Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй		
2	Эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй		
3	Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкийг удирдахад харшлахгүй байх		
4	Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх		
5	Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх		
6	Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх		
7	Дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс таваас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай байх		
8	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх		

Үнэлгээг хийсэн:

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОЛОН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА / ГИШҮҮН

.....

Огноо: онсар өдөр

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ҮНЭЛГЭЭ

НЭГ. Нэр дэвшигчийн эцгийн нэр, нэр: _____

1.Компанийн тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх

№	Шалгуур	Үнэлгээ (Тийм/Үгүй)	Баталгаажуулах материал
1	Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй		
2	Төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх		
3	Эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй		
4	Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харшлахгүй байх		
5	Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх		
6	Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх		
7	Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх		
8	Банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс таваас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай байх		
9	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх		
10	Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран банк, түүний нэгдлийн оролцогчийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг		

	эзэмшдэггүй буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш байх		
11	Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь банк болон түүний нэгдлийн оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн таван жилийн хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтан, эсхүл сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүй байх		
12	Тухайн банкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх		
13	Банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй байх		
14	Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх		
15	Банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, бусад ажилтны холбогдох этгээд биш байх		
16	Банктай бизнесийн аливаа холбоогүй байх		

2. Нэмэлт мэдээлэл

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Банктай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч байгууллагад ажил үүрэг хашдаггүй байх	
2	Хангалттай цаг зарцуулж ажиллах боломжтой байх /Монголбанкны “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг хүлээн зөвшөөрсөн/	
3	Ёс суртахууны өндөр төлөвшилтэй байх	
4	Идэвх санаачлагатай, хариуцлагатай байх	
5	Аливаа асуудалд дүн шинжилгээ хийж, асуудлыг оновчтой шийдвэрлэх чадвартай байх	
6	Бусад	
	Нийт оноо	

Үнэлгээг хийсэн:

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОЛОН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА/ГИШҮҮН

.....

Огноо:онсарөдөр

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг
сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмын
Хавсралт 4



ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

№	Нэр дэвшигчийн эцгийн нэр, нэр	ТУЗ-ийн гишүүний ангилал (Ердийн/Хараат бус)	Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх (Тийм / Үгүй)	Нэмэлт шалгуур үзүүлэлтийн оноо (Зөвхөн хараат бус гишүүнд хамаарна)

Дүгнэлт: Дээрх үнэлгээг үндэслэн дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч

1.
2.
3.
4.
5.
6.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч

7.
8.
9.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОЛОН
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА

.....

Огноо:онсарөдөр